



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/38/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Д.Нарантуул

Утас: 99019800

цахим хаяг: narantuul.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Нэмэлт төсөв	14
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ГИХББДГ	Гадаадын иргэн харьяатын баруун бүс дэх газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Э.ДӨЛБАДРАЛ ТАНАА

2023.02.03 № 2/09
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй, тайлант онд авлага их хэмжээгээр нэмэгдүүлсэн, шатахуун, томилолтын зардлын зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй, барилгын захиалагчийн хяналтын зардлыг холбогдох журмын дагуу зарцуулаагүй байгууллагын үйл ажиллагааны зардалд зарцуулсан, байгууллагын дотоод хяналтын баг томилоогүй, цагийн бүртгэл хөтлөөгүй цалин, томилолтын мөнгө олгосон, анхан шатны баримтын бүрдүүлэлт бүрэн бус, албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж урамшуулал олгоогүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1.3-д "аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна", 1.5-д "... Журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам" тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө", Засгийн газрын 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-д "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно:", Барилга хот байгуулалтын сайдын 83 тоот тушаалын хавсралтад "барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

санхүүжүүлэх зардлын нэр төрөл, зарцуулах зардлын ангилал” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор Улсын төсвийн хөрөнгө оруулалтын барилгын захиалагчийн хяналтын орлогоор 238.0, хувийн хэвшлийн хяналтын орлогоор 41.0, газрын дуудлага худалдааны орлогоос 225.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэн орон нутгийн төсөвт 225.5, улсын төсөвт 73.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудалгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Бусад асуудлын хэсэгт аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудлыг оруулна.

АДБОУС 2706.10-д зааснаар газрын дуудлага худалдаа, газар олголт зэрэг асуудлыг аудитын хамрах цаг хугацаанаас шалтгаалан аудитад хамруулаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>18,307,298</u>	<u>123,128,238</u>
33	АВЛАГА	274,500	116,200
335	Бусад авлага	274,500	116,200
3351	Байгууллагаас авах авлага	274,500	116,200
34	УРЬДЧИЛГАА	-	102,676,000
34600	Урьдчилж гарсан зардал	-	102,676,000
35	БАРАА МАТЕРИАЛ	18,032,798	20,336,038
351	Түүхий эд материал	2,197,410	67,200
35110	Тусгай зориулалттай материал	2,197,410	67,200
354	Хангамжийн материал	15,835,388	20,268,838
35410	Бичиг хэргийн материал	2,816,912	2,698,562
35420	Аж ахуйн материал	11,257,176	14,808,976
35440	Түлш, шатах тослох материал	-	1,000,000
35470	Бусад хангамжийн материал	1,761,300	1,761,300
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>965,919,527.53</u>	<u>950,355,883.74</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	965,919,527.53	950,355,883.74
392	Биет хөрөнгө	908,019,527.53	892,455,883.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	814,830,700	814,830,700
39202	Хуримтлагдсан элэгдэл	(47,931,217.56)	(63,908,290.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	113,789,800	113,789,800
39204	Хуримтлагдсан элэгдэл	(41,302,155.57)	(60,267,122.25)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	407,872,127.76	456,457,699.76
39206	Хуримтлагдсан элэгдэл	(363,611,934.03)	(390,887,991.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,335,670.86	31,906,170.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,419,583.82)	(22,305,828.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,610,576.80	19,750,576.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,154,456.91)	(6,909,831.39)
393	Биет бус хөрөнгө	57,900,000	57,900,000
39301	Програм хангамж	880,000	880,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(880,000)	(880,000)
39303	Бусад биет бус хөрөнгө	57,900,000	57,900,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>984,226,825.53</u>	<u>1,073,484,121.74</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>984,226,825.53</u>	<u>1,073,484,121.74</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	984,226,825.53	1,073,484,121.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	254,822,164.94	254,822,164.94
51101	Өмч: - төрийн	254,822,164.94	254,822,164.94
512	Хуримтлагдсан үр дүн	728,243,631.75	817,500,927.96
51210	Өмнөх үеийн үр дүн	728,243,631.75	728,243,631.75
51220	Тайлант үеийн үр дүн	-	89,257,296.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,161,028.84	1,161,028.84
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>984,226,825.53</u>	<u>1,073,484,121.74</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	822,627,641.38	1,084,766,604

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,502,091.38	15,654,550
120	Нийтлэг татварын бус орлого	66,502,091.38	15,654,550
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	66,502,091.38	15,654,550
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	55,769,823.38	3,646,050
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,692,400	5,008,500
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,039,868	7,000,000
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	275,508,250	1,069,112,054
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	487,412,200
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	487,412,200
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	480,617,300	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	233,614,150	578,839,854
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,150,000	235,728,413.60
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	168,306,656.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	223,464,150	174,804,784.40
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,331,600	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,331,600	-
1330	Төсвийн захирагчдаас	2,562,500	2,860,000
133003	Хөрөнгийн	2,562,500	2,860,000
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	862,778,627.19	994,151,897.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	862,778,627.19	994,151,897.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	667,496,813.81	685,160,627.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	389,266,093	373,471,913
210101	Үндсэн цалин	289,902,191	301,149,804
210102	Нэмэгдэл	62,497,657	65,387,109
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,777,000	6,935,000
210104	Урамшуулал	-	-
210105	Гэрээт ажлын хөлс	29,089,245	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,376,692	46,934,222
210201	Тэтгэврийн даатгал	35,338,068	32,529,666
210202	Тэтгэмжийн даатгал	3,892,659	3,734,126
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,114,128	2,987,301
210204	Ажилгүйдлийн даатгал	730,167	698,466
210205	Эрүүл мэндийн даатгал	7,301,670	6,984,663
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,601,134	39,084,806
210302	Түлш, халаалт	33,160,050	33,160,050
210303	Цэвэр, бохир ус	5,441,084	5,924,756
2104	Хангамж, бараа материалын зардал	37,175,024	47,457,568
210401	Бичиг хэрэг	9,444,292	8,500,115
210402	Тээвэр, шатахуун	16,107,753	33,024,553
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	211,200	246,100
210404	Ном, хэвлэл	2,008,440	3,632,800
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,249,726	2,054,000
210408	Бараа материал акталсны зардал	6,153,613	-

2105	Нормативт зардал	1,220,300	515,300
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,220,300	515,300
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,195,000	7,672,000
210604	Урсгал засвар	3,195,000	7,672,000
2107	Томилолт, зочны зардал	14,444,600	16,938,900
210702	Дотоод албан томилолт	14,444,600	16,938,900
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,249,420	55,541,656
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,818,820	55,200,656
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	27,400
210803	Даатгалын үйлчилгээ	430,600	313,600
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	109,968,550.81	97,544,262.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,891,950	29,684,547
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,076,600.81	67,859,715.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,281,813.38	308,991,270.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,300,000	1,577,100
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,300,000	1,577,100
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	106,453,840	225,546,320
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	106,453,840	225,546,320
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	87,527,973.38	81,867,850
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	63,612,723.38	8,812,850
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	23,915,250.00	73,055,000
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(40,150,985.81)	90,614,706.21
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,357,410
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	1,357,410
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,357,410)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(40,150,985.81)	89,257,296.21

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	825,268,013.38	1,119,262,447.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	63,612,723.38	8,812,850
120	Нийтлэг татварын бус орлого	63,612,723.38	8,812,850
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	63,612,723.38	8,812,850
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	55,769,823.38	3,646,050
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,842,900.00	5,166,800
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	761,655,290.00	1,110,449,597.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	487,412,200
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	487,412,200
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	480,617,300	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	241,706,390	623,037,397.20
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	18,242,240	282,925,956.80

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	168,306,656.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	223,464,150	171,804,784.40
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,331,600	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,331,600	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	791,274,013.38	971,290,375.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	791,274,013.38	971,290,375.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	595,052,200	662,070,705.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	389,264,716	373,601,564
210101	Үндсэн цалин	289,900,814	301,279,455
210102	Нэмэгдэл	62,497,657	65,387,109
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,777,000	6,935,000
210105	Гэрээт ажлын хөлс	29,089,245	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,378,020	46,056,600
210201	Тэтгэврийн даатгал	35,649,120	31,883,700
210202	Тэтгэмжийн даатгал	3,682,200	3,543,200
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,945,800	2,834,600
210204	Ажилгүйдлийн даатгал	736,500	708,600
210205	Эрүүл мэндийн даатгал	7,364,400	7,086,500
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,140,900	39,084,806
210302	Түлш, халаалт	33,160,050	33,160,050
210303	Цэвэр, бохир ус	5,980,850	5,924,756
2104	Хангамж, бараа материалын зардал	18,763,663	40,429,450
210401	Бичиг хэрэг	4,196,800	3,801,000
210402	Тээвэр, шатахуун	12,073,963	31,799,850
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	211,200	246,100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,281,700	4,582,500
2105	Нормативт зардал	2,276,000	268,200
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,276,000	268,200
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,390,700	4,605,000
210604	Урсгал засвар	1,390,700	4,605,000
2107	Томилолт, зочны зардал	14,444,600	16,938,900
210702	Дотоод албан томилолт	14,444,600	16,938,900
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,379,260	102,476,699.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,818,820	55,850,656
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	37,600	27,400
210803	Даатгалын үйлчилгээ	430,600	313,600
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,092,240	46,285,043.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,014,341	38,609,486
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,014,341	38,609,486
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	196,221,813.38	309,219,670
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,240,000	1,805,500
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,240,000	1,805,500
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	106,453,840	225,546,320
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	106,453,840	225,546,320
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	87,527,973.38	81,867,850
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	63,612,723.38	8,812,850
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	23,915,250	73,055,000
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	33,994,000	147,972,072
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	33,994,000	147,972,072

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,994,000	147,972,072
2200	Дотоод эх үүсвэрээр	33,994,000	147,972,072
222001	Тоног төхөөрөмж	-	102,676,000
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,994,000	45,296,072
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(33,994,000)	(147,972,072)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,822,164.94	1,303,589.97	767,502,056.43	1,023,627,811.34
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	142,561.13	142,561.13
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,822,164.94	1,303,589.97	767,644,617.56	1,023,770,372.47
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(40,150,985.81)	(40,150,985.81)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,822,164.94	1,161,028.84	728,243,631.75	984,226,825.53
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,822,164.94	1,161,028.84	728,243,631.75	984,226,825.53
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,822,164.94	1,161,028.84	728,243,631.75	984,226,825.53
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	89,257,296.21	89,257,296.21
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	254,822,164.94	1,161,028.84	817,500,927.96	1,073,484,121.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	487,412,200	487,412,200
21	УРСГАЛ ЗАРДАЛ	487,412,200	487,412,200
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	485,606,700	485,606,700
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	369,116,800	369,116,800
210101	Үндсэн цалин	305,706,700	296,794,691
210102	Нэмэгдэл	53,239,500	65,387,109
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,170,600	6,935,000
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,056,600	46,056,600
210201	Тэтгэврийн даатгал	31,883,700	31,883,700
210202	Тэтгэмжийн даатгал	3,543,200	3,543,200
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,834,600	2,834,600
210204	Ажилгүйдлийн даатгал	708,600	708,600

210205	Эрүүл мэндийн даатгал	7,086,500	7,086,500
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,476,200	31,476,200
210301	Гэрэл, цахилгаан	3,208,700	-
210302	Түлш, халаалт	23,971,200	25,551,444
210303	Цэвэр, бохир ус	4,296,300	5,924,756
2104	Хангамж, бараа материалын зардал	9,356,700	9,356,700
210401	Бичиг хэрэг	1,843,400	1,843,400
210402	Тээвэр, шатахуун	6,343,700	6,343,700
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	246,100	246,100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	923,500	923,500
2105	Нормативт зардал	268,200	268,200
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	268,200	268,200
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	149,000	149,000
210604	Урсгал засвар	149,000	149,000
2107	Томилолт, зочны зардал	5,883,900	5,883,900
210702	Дотоод албан томилолт	5,883,900	5,883,900
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	341,000	341,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	27,400	27,400
210803	Даатгалын үйлчилгээ	313,600	313,600
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,958,300	22,958,300
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,958,300	22,958,300
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,805,500	1,805,500
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,805,500	1,805,500
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,805,500	1,805,500
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	487,412,200	487,412,200
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	487,412,200	487,412,200
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	37	37
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	31	31
620003	Үйлчлэх ажилтан	2	2
620004	Гэрээт ажилтан	3	3
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	32	32
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	241,706,390	623,037,397.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	241,706,390	500,461,397.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	111,337,300	201,860,077.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,533,556	4,484,764
210101	Үндсэн цалин	4,524,654	4,484,764
210102	Нэмэгдэл	1,251,957	-
210105	Гэрээт ажлын хөлс	8,756,945	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	668,320	-

210201	Тэтгэврийн даатгал	668,320	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	7,608,606
210302	Түлш, халаалт		7,608,606
2104	Хангамж, бараа материалын зардал	9,363,463	31,072,750
210401	Бичиг хэрэг	840,000	1,957,600
210402	Тээвэр, шатахуун	7,032,563	25,456,150
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,490,900	3,659,000
2105	Нормативт зардал	1,880,000	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,880,000	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000	4,456,000
210604	Урсгал засвар	1,200,000	4,456,000
2107	Томилолт, зочны зардал	-	11,055,000
210702	Дотоод албан томилолт		11,055,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,911,060	102,135,699.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,818,820	55,850,656
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,092,240	46,285,043.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,780,901	41,047,258
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,780,901	41,047,258
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	130,369,090	298,601,320
2132	Бусад урсгал шилжүүлэг	130,369,090	298,601,320
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	106,453,840	225,546,320
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	23,915,250	-
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн, төвлөрүүлэх шилжүүлэг		73,055,000
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	122,576,000
2200	Дотоод эх үүсвэрээр	-	122,576,000
222001	Тоног төхөөрөмж		122,576,000
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	241,706,390	623,037,397.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	241,706,390	623,037,397.2
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	18,242,240	282,925,956.8
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		168,306,656
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	223,464,150	171,804,784.4

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас 2022 онд газрын харилцааны салбарын албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор “Хүний нөөцийн хөгжлийг дэмжих” жилийн хүрээнд Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь цахим шилжилтийг эрчимжүүлэх, албан хаагчдын ур чадварыг үнэлж, мэргэшүүлэх сургалтад

хамруулан үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах гэсэн зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/123 тоот тушаалаар Ховд аймгийн Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрыг 37 орон тоотой байхаар батлагдаж, газрын удирдлагын хэлтэс, Барилга хот байгуулалтын гэсэн 2 хэлтэстэй 37 албан хаагчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Тус газар нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 52 зорилт, 126 арга хэмжээ, 6 чиглэлийн хүрээнд боловсруулж, 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга, аймгийн Засаг даргаар хянуулан баталсан байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас барилгын захиалагчийн техник хяналтын зардлаас улсын төсөвт 70.0 сая төгрөг төвлөрүүлэхээс батлагдаж 81,867.9 мянган төгрөг төвлөрүүлж 116.9%, орон нутгийн төсөвт газрын дуудлага худалдааны орлогоос 100.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 225.5 сая төгрөг төвлөрүүлж 225.5% -иар тус тус давуулан биелүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Газрын тухай багц хууль, Барилгын тухай хууль, газрын харилцаа, барилга, хот байгуулалтын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, Хаягжуулалтын тухай хууль, Газрын төлбөрийн тухай, Геодези зураг зүйн тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль, Хот байгуулалтын тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай зэрэг хууль тогтоомжуудыг үйл хэрэгжүүлэн ажиллаж байна.

2022 онд Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдсан, Газрын тухай хуульд 4 удаа, Барилгын тухай хуульд 5 удаа, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд 2 удаа, Хаягжуулалтын тухай хуульд 1 удаа, Газрын төлбөрийн тухай хуульд 2 удаа, Геодези зураг зүйн тухай хуульд 3 удаа, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд 1 удаа, Хот байгуулалтын тухай хуульд 1 удаа, Эрчим хүчний тухай хуульд 2 удаа, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд 3 удаа нэмэлт өөрчлөлтүүд оржээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Газрын даргын тушаалаар Өмч хамгаалах байнгын зөвлөлийг томилж, хийх ажлын төлөвлөгөөг жилээр нь төлөвлөн 2022 онд зөвлөлөөс хэрэгжүүлсэн ажлын тайланг 5 удаа хэлэлцэн байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж тайлант онд 7 ажлыг төлөвлөснөөс 1 ажил буюу ашиглалтын хугацаа дууссан цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг актлуулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас 2022 оны 10 сард Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын үйл ажиллагаанд 2022 оны төлөвлөгөөт хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгдэж 73.4 хувьтай үнэлүүлэн 44 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн байна.

ТӨБЗГ-ын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 08-ны А/27 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх комиссыг 12 сарын 26-ны А/51 тоот тушаалаар томилон, тооллогыг зохион байгуулж хөрөнгө бүртгэн авах, дутагдсан болон ашиглалтгүй хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар санал дүгнэлтийг гаргажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 89.3 сая төгрөгөөр буюу 9.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая. төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.3	102.8	102.5
Бараа материал	18.0	20.3	2.3
Үндсэн хөрөнгө	965.9	950.4	(15.6)
Нийт хөрөнгө	984.2	1,073.5	89.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	984.2	1,073.5	89.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	984.2	1,073.5	89.3

Дээрх хүснэгтээс харахад Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 89.3 сая төгрөгөөр өссөний материаллаг нөлөө нь авлагын данстай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 624.6, орон нутгийн төсвөөс 49.1 сая төгрөг нийт 673.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 172.1 сая төгрөгөөр бууруулж, 501.6 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд анх батлагдсан 501.6 сая төгрөгийн төсвийг 14.2 сая төгрөгөөр бууруулан тодотгон баталж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 487.4 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 487.4 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 487.4 сая төгрөг буюу 100 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая. төгрөгөөр/				
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
	Газрын зураглал, кадастр -71504			
1	Үндсэн үйл ажиллагаа - 80101	462.6	462.6	100
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал - 80802	1.8	1.8	100
3	Барилгын техник хяналт - 82804	23.0	23.0	100
	ДҮН	487.4	487.4	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 102.7, захиалагчийн техник хяналтын зардлаас 196.4, газрын дуудлага худалдааны орлогоор 225.5, газрын дуудлага худалдааны дэнчингийн орлогоос 46.3, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар орон нутагт хийгдэж буй барилга угсралтын ажлын техник хяналтын зардлаас 41.0, ГИХББДГ-аас харуул хамгаалалтын үйлчилгээний зардалд 7.2, бусад орлогоос 3.0, авлагаас 0.9, нийт 623.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орон нутгийн төсөвт газрын 225.5, улсын төсөвт /100900029004/ 73.1, газрын дуудлага худалдааны дэнчинг хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагад 46.3, харуул хамгаалалтын зардалд 14.4, түлш халаалтын зардал 7.6,

Металл эдлэхүүний лабораторийн тоног төхөөрөмж худалдан авахад 102.7, албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлтөд 7.0, захиалагчийн хяналтын үйл ажиллагааны зардалд 149.1 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Барилга хот байгуулалтын яам GIZ Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс “Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх” төслийн хүрээнд дулааны алдагдлыг хэмжих Testo-868 маркийн 5.9 сая төгрөгийн багаж хэрэгслийг үнэ төлбөргүй олгожээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.3 сая төгрөгийн төлбөрийн акт бичигдэж бүрэн барагдуулсан, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2022 оны 01 дүгээр сарын 20-ноос 02 дугаар сарын 02-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 41 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 862.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 17.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 13.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 995.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 19.9 сая, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 15.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус газар нь холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаагүй байна.

Ховд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцас, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан холбоотой заалтууд хамаарахгүй байна.

6 дугаар зүйлд заасан шатахууны зардалд тайлант онд 33.0 сая төгрөгийг зарцуулахдаа дотоод хяналт хэрэгжүүлээгүй, байгууллагын дарга нь шатахууны зөвшөөрлийн бичгээ олгодог, улс орон нутгийн санхүүжилтээр баригдаж байгаа барилгуудад захиалагчийн хяналтын ажлаар ажилласан эсэх тодорхой бус, хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтэс, ЗДТГ-т шатахуун олгодог, томилолтоор ажиллаагүй газарт км зөрүүтэй бичиж 11.5 сая төгрөгийн зардал гаргасан байна.

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын хувьд тус байгууллага нь 2022 онд 16.9 сая төгрөгийн томилолтын зардлыг албан хаагчид олгохдоо албан хаагчдыг томилолтоор ажилласан хугацаа, амарсан, ажилдаа ирсэн, явсан эсэхийг цагийн бүртгэл хөтлөөгүйгээс нотлох анхан шатны баримтгүй, дарга Улаанбаатар хотод удирдах ажилтны зөвлөгөөнд байгууллагын машинаар явсан, ирэхдээ онгоцны зардал гаргасан, бүрэн бус томилолтын хуудсаар албан хаагчдад нийт 3.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдлийн зардалд Хашаандаа сайхан амьдарцгаая төслийн гишүүдэд 16.7 сая төгрөгийн цалин, шимтгэлийн зардал гаргасан.

11 дүгээр зүйлд заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд байгууллагын дотоод журмын дагуу батлагдсан төсвийн хүрээнд 1.8 сая төгрөгийн зардал гаргасан.

12 дугаар зүйлд заасан бусад хангамжийн зүйл худалдан авах зардалтай холбоотой байгууллагын үйл ажиллагаанд хэрэгцээ шаардлагагүй 0.4 сая төгрөгийн материал худалдан авсан.

13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардалд Металл хийц эдлэхүүний лабораторийн тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг 10 дугаар сард зохион байгуулан 102.7 сая төгрөгийн санхүүжилтийн урьдчилгаа олгон их хэмжээний авлага үүсгэсэн байна.

15 дугаар зүйлд заасан бусад зардлын хувьд захиалагчийн хяналтын зардалд байгууллагын үйл ажиллагааны зардал, төсөл хөтөлбөр, албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлт, тоног төхөөрөмж худалдан авах, Хашаандаа сайхан амьдарцгаая төслийн гишүүдийн цалинд 47.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 3 байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын хөлс илүү олгосон, шаардлагагүй бараа материал худалдан авсантай холбоотой 1.3 сая төгрөгийн төлбөрийн акт бичигдэж бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1.3	1	1.3	100
Нийт дүн	1	1.3	1	1.3	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар газрын дуудлага худалдаа, барилгын захиалагчийн хяналтын зардлаас оруулах орлого, зарцуулалт, төлбөртэй үйлчилгээний орлого, шатахууны зарцуулалтыг анхаарч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 69.3 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 0.9 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд өмнөх аудитаар бичигдсэн төлбөрийн актыг байгууллагын дансаар дамжуулан орон нутгийн дансанд төвлөрүүлэх 0.9 сая төгрөгийн орлогоор хүлээн зөвшөөрч алдааг залруулсан болно.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 68.4 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 4.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 63.8 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай хийсэн гэрээгээр талоноор авсан шатахууны худалдан авсны урамшуулалд 0.18 сая төгрөгийн үнэ төлбөргүй олгосон шатахууныг орлогоор бүртгээгүй, томилолтоор ажилласан эсэх нь тодорхой бус Улаанбаатар хот, Баян Өлгий аймаг, Булган суманд ажилласнаар жолоочийн замын хуудсанд км илүү тооцож 3.5 сая төгрөгийг шатахуун зарцуулснаар тооцоо бодсон зэрэгтэй холбоотой нийт 3.6 сая төгрөг,

5.1.2 Байгууллагад хэрэгцээгүй материал худалдан авсан, УБ хотод удирдах ажилтны зөвлөгөөнд байгууллагын автомашинаар явсан, ирэхдээ онгоцны зардал гаргасан, бүрэн бус томилолтын хуудсаар томилолтын мөнгө олгосон нийт 1.0 сая төгрөг,

5.2 Зөвлөмж

5.2.1 Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант оны эцэст Металл хийц эдлэхүүний лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааг зохион байгуулан гэрээ байгуулж санхүүжилтийг олгосон зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1 дэх заалтыг мөрдөн ажиллах

5.2.2 Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын удирдлага захиалагчийн хяналтын баг, бүрэлдэхүүнгүйгээр сумдад томилолтоор ажилласан, томилолтоор ажиллах зайлшгүй шаардлага байсан эсэх нь тодорхой бус, албан хаагчид томилолтоор ажиллах удирдамжгүй, томилолтын хуудас засвартай, ажлын тайлан болон ажилласан сум, он, сар, өдөр зөрүүтэй бичиж 3.2 сая төгрөгийн томилолтын зардал олгосон.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах

5.2.3 Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын удирдлага нь дотоод хяналтын баг томилоогүй, цагийн бүртгэл хөтлөөгүй, томилолтоор ажилласан, ээлжийн амралт, ажиллаж байгаа эсэхийг нотлох баримтгүй зэрэг зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Able.mn intrative.mn дотоод цахим программ хангамжийг ашиглан цагийн бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлэн ажиллах

5.2.4 Үр дүнгийн урамшуулалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгоогүй, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар холбогдох байгууллагын тушаал шийдвэрээр 4.8 сая төгрөгийн төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Холбогдох тогтоолын дагуу үр дүнгийн урамшууллыг олгох хэвших

5.2.5 Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон сууцны барилга угсралтын ажлын захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээг 2022 онд 22 иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай хийж гэрээнд 6 орон сууцны барилга ашиглалтад ороогүй, бусад ашиглалтад орсон орон сууцны барилгын компаниас техник

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хяналтын зардлын төлбөрийг байгууллагын дансанд бүрэн төвлөрүүлээгүй, иргэдэд газрын төлбөрийн үйлчилгээтэй холбоотой асуудлаар ил тод мэдээлэл өгдөггүй зэрэг зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: 2023 оны эхний улиралд багтаан байгууллагын дансанд төвлөрүүлэх, үйлчилгээний төлбөрийн талаар иргэдэд мэдээлэл өгөх

5.2.6 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Захиалагчийн хяналтын зардлаас Барилга хот байгуулалтын сайдын 83 тоот тушаалын хавсралтад заагдаагүй Хашаандаа сайхан амьдарцгаая төслийн цалингийн зардалд 16.8, байгууллагын үйл ажиллагааны тоног төхөөрөмж бэлтгэсэн, байгууллагын урсгал засварт 24.0, албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлтөд 7.0 нийт 47.7 сая төгрөгийг зарцуулсан,

Өгсөн зөвлөмж: Холбогдох журам, тушаалд заасан зардлыг санхүүжүүлэх, төсөл арга хэмжээнд зардал гаргахгүй байх

5.2.7 Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатахууны зардалд хяналт хэрэгжүүлээгүйгээс жолоочийн замын хуудсанд томилолтоор ажилласан эсэх нь тодорхой бус, он, сар, өдөр зөрүүтэй, байгууллагын удирдлага нь шатахууны зөвшөөрлийн бичгийг олгодог, томилолтоор ажиллаагүй сум, газарт 3.9 сая төгрөг, аймгийн Засаг даргын тамгын газар, Хөгжлийн бодлого төлөвлөлт, бодлого, хөрөнгө оруулалт хэлтэст 4.1 сая төгрөгийн шатахуун олгож ямар ажилд зарцуулсан нь тодорхой бус нийт 8.0 сая төгрөгийн шатахуун зарцуулсан зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, бусад байгууллагад шатахуун олгохгүй байх

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /сая.төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн үр дүнгийн тайланд орлого илүү бүртгэсэн	1	0.9			1	0.9	1	0.9
Дүн	1	0.9			1	0.9	1	0.9

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бүрэн бус томилолтын хуудсаар томилолтын мөнгө олгосон	1	3.2					1	3.2
Захиалагчийн хяналтын зардлаас байгууллагын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн	1	47.7					1	47.7
дотоод хяналтын баг томилоогүй дотоод хяналт хэрэгжээгүй	1	-					1	

Шатахууны зарцуулалтад тавих хяналтгүй,	1	3.5	1	3.5				
Албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгоогүй	1	4.9					1	4.9
Гэрээнд зааснаар орон сууцны барилгын компаниас техник хяналтын зардлыг төлүүлээгүй	1						1	
Дүн	6	59.3	1	3.5			5	55.8

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая. төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Байгууллагад хэрэгцээгүй материал худалдан авсан, бүрэн бус томилолтын хуудсаар томилолтын мөнгө олгосон, онгоцны давхардуулан гаргасан	1	1.1	1	1.1	-	-	-	-
Захиалагчийн хяналтын зардлаас түлээ нүүрсний хөнгөлөлт, ЗДТГ, ИТХ-д шатахуун олгосон,	1	8.0					1	8.0
тайлант оны эцэст худалдан авах ажиллагаа зохион байгуулан авлага их хэмжээгээр үүсгэсэн	1						1	
Дүн	3	9.1	1	1.1			2	8.0

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 02/А2160424

Ховд

ХОА-2022/38/НА/СТА-ТШЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд байгууллагад хэрэгцээ шаардлагагүй материал худалдан авсан, бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээгээр урамшуулалд олгосон шатахууныг орлогод аваагүй, бүрэн бус томилолтын хуудсаар томилолтын зардалд 1136400 төгрөгийг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 1136400 /нэг сая нэг зуун гучин зургаан мянга дөрвөн төгрөг/-ийг Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 04 дүгээр сарын 20-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын дарга Э.Делбадрал, нягтлан бодогч Г.Эсбаатар нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ТЭРТҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОСОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР  Д.НАРАНТУУЛ

1

¹ Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061


**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 05/A2160424

Ховд

ХОА-2022/38/НА/СТА-ТШЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд шатахууны зардлыг хяналтгүйгээр зарцуулсан, сумдад явснаар тооцон км илүү бичиж шатахууны зардалд 3535640 төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 3535640 /гурван сая таван зуун тавин гурван мянга зургаан зуун дөчин төгрөг/-ийг Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 04 дүгээр сарын 20-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын дарга Э.Дөлбадрал, нягтлан бодогч Г.Эсбаатар нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Г.БОЛОДБААТАР

АХЛАХ АУДИТОР 

Д.НАРАНТУУЛ

1

¹ Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061